



Сэдэв: Яруу найргийн айзам хэмнэлийн үүргийг тайлбарлая

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Айзам зүй гэдэг нь тухайн хэлний хууль зүйгээр нөхцөлдөн бүтсэн шүлгийн айзамт байгууллын зүй тогтол, дотоод хэмнэлийг судалдаг. Шүлэглэсэн зохиолын бүтэц байгууллын гол зүйл нь айзам (ритм) юм.



Гүүг гүүг _ гүүг гүүг _ гүүг гүүг
_ гүүг гүүг

1. Энэ ямар шувуу вэ? (.....)

Зуны тунгалаг өглөө ойгоос сонсогдох энэ дууг төсөөлөн шувуун дууны хэмнэлээр олон давтамжтай ширээ тогшоорой. Чиний гаргаж байгаа энэ чимээ бас хөдөлгөөн чинь айзмыг бий болгож байна.

Айзам гэдэг нь аль нэгэн төсөөтэй үзэгдлийн тодорхой хугацаанд давтагдах зохилдсон хөдөлгөөнийг хэлнэ.

2. Дэлхийд нэрээ гаргаж буй язгуур урлагийн ямар хамтлаг мэдэх вэ? Монгол үндэсний язгуур урлагийн хамтлагуудыг яагаад дэлхий нийт сонирхож байна гэж бодож байна вэ? Чиний бодол.....

Магадгүй байгалийн дуу авиаг гаргадаг нь илүү амьд сонсогддог байж болно. Ан амьтан гол ус гэх мэт байгалийн авиа бол бүх дуу чимээний язгуур анхдагч мөн байх.

Айзам бол урлагаас өмнө байгалийн үзэгдэлд байсан бөгөөд хүн түүнийг хөдөлмөртөө шингээж ашиглажээ. Шүлгийн айзмыг хөдөлмөрөөс үүссэн гэж үздэг.

Явуухулан бол эх орон, байгаль дэлхийн гайхамшигт дуучин, ертөнц өөрийгөө дуулуулахаар илгээсэн “алтан гургалдай” буюу.

“Мөнгөн хазаарын чимээ” /1959/ хэмээх энэ шүлгийг мэдрэхийн тулд нүүдэлчин ахуйг ойлгох хэрэгтэй юм. Яруу найрагт нүүдэлчин айл. Нам гүм аниргүй шөнө. Өрх бүтээлгээстэй. Өрхөн завсраар шургах сарны туяа унийн углуургаар гэрэлтэх нь ямархан нэгэн нууцлаг ахуй, далд явдлын шижим аж...”

(Г. Мэнд-Ооёо “Гол ус тунгалагших цаг”. УБ., 2011, 145-р тал)

Г. Мэнд-Ооёо “Гол ус тунгалагших цаг” номыг уншиж их зохиолч Б.Явуухуланг яагаад **дорнын их яруу найрагч** гэж нэрлэх болсныг мэдэж аваарай.

3. Мөнгөн хазаар, эмээлийг монгол малчид ямар үед эдэлж хэрэглэдэг болохыг эргэцүүлээрэй. Шүлгийг ийнхүү нэрлэсэн учрыг юу гэж бодож байна вэ?

.....
.....
.....

Б. Явуухулан

МӨНГӨН ХАЗААРЫН ЧИМЭЭ

Зорин ирэх амрагаа хүлээхэд
Морин төвөргөөн зүрхнээ хоногшиж
Шөнийн чимээгүй гадаа налайн
Унийн углуургаар саран гэрэлтэнэ.
 Өнчин дэрэн дээр нойр хулжсан
 Ухаангүй дурлалын урхинд байхад
 Мөнгөн хазаарын бүдэг чимээ
 Онгон зүрхийг цочоон баясгана

4. Шүлгийг мэдэрч, уран яруу уншиж үзээрэй.

5. Шүлгийн хэлбэр бүтцийг ажиглан бадаг, мөр, үгийн тоог нөхөж бичээрэй.

Тус шүлэг хэдэн бадагтай байна вэ? ()

Бадаг бүр хэдэн мөртэй байна вэ? ()

Мөр бүр хэдэн үгтэй байна вэ? ()

6. Ижил авиагаар толгой сүүл холбоогүй ч уншихад айзам хэмнэлтэй байгаагийн учир юунд байна вэ?

.....
.....
.....
.....

7. Морин төвөргөөн гэх үгийн тайлбарыг толь бичгээс харж мөр бүрд байх үгийн тоотой холбон тайлбарлаарай.

Төвөргөөн-

8. https://www.youtube.com/watch?v=hQ3eF_9Cv0Q “Морин төвөргөөн” хэмээх аялгууг сонсож “Мөнгөн хазаарын чимээ” шүлгийн айзам хэмнэлтэй харьцуулан сэтгэгдлээ бичээрэй.

.....
.....
.....
.....

Дууссан:он ...сар ...өдөр

- 3. Эвлүүлсэн шүлгээ гурав гурван мөрөөр нь бадаглаж айзам хэмнэлийг мэдэрч уншаарай.
- 4. Бадаг бүрийг уншихдаа цагийн тооцоолол гаргаж үзээрэй. Нэг бадгийг уншихад ойролцоогоор хэдэн секунд зарцуулж байна вэ?

Нарс найгаа л Навчис хийсээ л Уулын оройд будан суугаа лсекунд
Шувуу буцаа л Хяруу унаа л Өвсөн толгойд цан буугаа лсекунд
Тал шарлаа л Мал холхио л Малчны сэтгэл гэнэт догдлоо лсекунд
Салхи сэвээ л Өрх дэвээ л Өлөн тоос тэнгэрт босоо лсекунд
Айлууд нүүгээ л Амрагууд холдоо л Аяа хөөрхий, нүүдэлчний намар аа гэж!секунд

- 5. Нэгэн ижил давтамжтай хэмнэл юуг бий болгох вэ?
А. Авиа Б. Эгшиглэл В. Айзам Г. Анир

6. Бадаг хэрхэн бүтсэн зүй тогтлыг ажиглан шүлгийн айзам хэмнэлд яаж нөлөөлснийг дүгнэн бичээрэй.

.....


.....

.....

.....

Сэдэв: Яруу найргийн эгшиглэлийн онцлогийг задлан шинжилье

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Шүлэглэсэн зохиолын авианы тогтолцоо, түүний загвар, зүй тогтлыг судалдаг шүлэг судлалын салбар ухааныг эгшиглэл зүй гэнэ. Эгшиглэл зүй нь яруу сонголонт чанарыг буюу уран хөг аялгууг бүрдүүлэгч гол хүчин зүйл болсон шүлгийн авианы үүргийг тусгайлан судална.

1. “Нүүдэлчний намар” шүлгийн хамгийн өвөрмөц санагдсан зүйл нь юу байсан бэ?

.....

2. Шүлэгт буцаж буй урин цаг, тэрхүү улиралд хүний сэтгэлийг дэнсэлгэсэн уйтай байдлыг илэрхийлэхийн тулд ямар арга ашигласан бэ?

.....

3. Шүлгийг хөг оруулж аялгуулаг сонсогдох нөхцөлд юу нөлөөлж байна вэ?

.....

4. Шүлгийн мөр болгоныг зургаар илэрхийлж болж байгааг юутай холбон тайлбарлаж болох вэ?

.....

5. Авиа утга илэрхийлэх үү? Шүлэгт ашигласан авиатай холбон тайлбарлахдаа сурах бичгийн 8-р талд байх судлал, шүүмжийг уншаарай.

Тайлбар:.....

.....

.....

Шүлэг бүр өөрийн агуулга хэлбэрт тохирсон хөг эгшиг, аялгуу хөгжимтэй байдаг.

“...Явуу багш бээр шүлгийг илүү, дутуу үггүй маш нарийн нягт, хөгжимлөг, айзам хэмнэл бүхий өө сэвгүй урлах ёстой гэж шаарддаг байсан бөгөөд яруу найргийн хамгийн гол зүйл бол дотоод сэтгэлийн дүрийг илэрхийлэх ёстой гэж үздэг байв...”

(Г. Мэнд-Ооёо “Гол ус тунгалагших цаг”. УБ., 2011, 147-р тал)

6. Б.Явуухулан “Хар ус нуурын шагшuurга” шүлэгт ямар авианы сонсогдох байдлыг хамгийн их ашиглаж хөгжимлөг болгосон байна вэ?

<i>Шүлэг</i>	<i>Авиа</i>	<i>Тайлбар</i>
<p>Хар ус нуурын шагшuurга Намрын салхинд исгэрнэ Харахад нэг л уйтгартай Намс намс бөхөлзөнө Нүдэнд торойх бараагүй Нуурын ус цэнхэртэнэ Нүцгэн уулс чимээгүй Өнгөн дээр нь сүүдэртэнэ Хээлэн үлээх салхи нь Нимгэн мандлыг нь бидэрлэнэ Зөөлөн исгэрэх шагшuurга Хөнгөн уйтгар төрүүлнэ Намрын сэрүүн унахлаар Нуурууд ийм л байдаг уу Хотон шувуудаа нүүчихлээр Хатан хар ус уйдаа юу</p>		

Сэдэв: Зохиолын хэл найруулгыг үнэлэх

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Зохиолын хэл гэдэг нь үндэсний хэлний бүхий л баялаг, дүрслэх арга хэрэглүүр ба боломжийг ашиглах буюу шинээр нээж, тухайн зохиолчоос өөр хэний ч хэлээгүй өвөрмөц онцлогтойгоор хэрэглэж юм үзэгдэл, хүний аж төрөл, зан байдал, үйл авирлалын дүр зургийг уншсан хэн бүхний санаа сэтгэлд (ургуулан бодоход) дуурайхуйц барим тавим тодорхой, цэцэн цэлмэг, уран яруу өгүүлж бодогдуулан бичихийн нэр болно.

(Ш. Гаадамба “Утга зохиолын онолын үндэс”. УБ., 1996. 101-р тал)

1. Шүлгийг мэдэрч уншаарай.

Намар говьд ингэ оройтох их шаналал

Намайг ижий зөөлөн аргадах их зөн

Аргамжаатай ботго уйлан буйлах их гуниг

Аав хүрлийн дуугаа хураах их санаашрал

Алдрайхан дүү зүүдэндээ үнэгчлэх их совин

Алсаас ингэ буйлсаар ирэх их гэмшил

Анхааран чагнаснаа ээж ухасхийх их баяр

Аргамжаатай ботго гунганасаар угтах их гомдол

Ботгоо үнэрлээд ингэ ивлэх их хайр

Ботго эхийгээ сөгдөж хөхөх их учрал

Ав адилхан хоёул нулимс унагах их уянга

Аав сая л дуу орох-их сайхан

(Д. Нямдорж “Тэнгэрийн дусал шиг цэнхэр тагтаа”. УБ., 2018. 10-р тал)

2. Шүлгийг уншихад ямар мэдрэмж төрсөн бэ? Хөөрч догдолсон мэдрэмж төрөв үү?

Гуниглаж санааширсан мэдрэмж төрөв үү? Юу сонсогдсон бэ?

Яагаад?.....

3. Тэр мэдрэмжийг төрүүлэхэд ямар үгс илүү нөлөөлсөн бэ?

4. Адилхан намрын тухай шүлэг болох “Нүүдэлчний намар”-аас гол ялгарах зүйл нь юу байв?

Адил тал: Намрын гуниг, санаашрал.....

Ялгаатай тал:.....

5. “Нүүдэлчний намар” шүлэгт буцаж буй урин цагийн гунигийг “Л” авиагаар илэрхийлсэн бол энэхүү шүлэгт ямар үгээр үзүүлсэн бэ?

А. аав-ээж Б. аргамжаатай ботго-ингэ В. баяр-хайр

6. Зохиолч говь нутагт үргэлжлэх намар цагийн гуниглангуй уянгалаг байдлыг ингэ буйлах, ботго гунганах дуугаар чихэнд сонсогдох шиг зураглажээ.

Хангай, тал, хот газрын намар цагийг ямар үгээр илэрхийлбэл хүний мэдрэмжид буух бол? /”Хангайн намар” “Талын намар” “Хотын намар” –аас аль нэгийг сонгон шүлэг зохиож болно/

.....
.....
.....
.....
.....

7. “Аав хүрлийн дуугаа хураах” - “Аав дуугаа хураах” хоёр ялгаатай юу?

Яагаад?.....

.....
.....
.....

8. Яруу найрагч Дагийраазайн Нямдорж говь нутгийн хүн мөн болов уу?

“Ботго эхийгээ сөгдөж хөхөх их учрал” гэсэн хэсэгтэй холбон таамаглаарай.

.....
.....
.....
.....
.....

Дууссан:онсар ...өдөр

Сэдэв: Зохиолын хэл найруулгыг үнэлэх

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр

1. Шүлгийг цээжлээд уран уншаарай

Өгсүүр замын дуу Т. Галсан

Онхол цонхолгүй вандан ширээ говийн

Оорцог тоорцог толгод минь намайг өршөө

Олонцог элээгээгүй дэгдээхэй насандаа би чинь

Оготно бор толгодоо уул...уул гэж эндүүрч явжээ

Оцор цацар довцгууд дундаа сүмбэр

Очир хэлбэрт уулс минь намайг өршөө

Отгон тэнгэрийн зулайг гишгэхээсээ урьд би

Оргил... Өндөр, оргил гэж уулсаа андуурч явжээ

Овоо тахилга нь бэлийн чулуугаар өндөрлөсөн

Отгонтэнгэр их хайрхан минь намайгаа өршөө

Отго жинстэй Алтайг өлмийлөхөөсөө урьд би

Огторгуйн багана гэж таныг эндүүрч явжээ

Он цагийн түүхийг мөнх цасандаа ботилсон

Онгод билгийн их Алтай минь намайгаа өршөө

Од зүлгүүрддэг Хималайг давахаасаа урьд би

Орчлонгийн зулай гэж Алтайгаа андуурч явжээ

Онхол цонхолгүй вандан ширээ говийн

Оорцог тоорцог толгод минь намайгаа бүү өршөө

Оосор бүчгүй сансрын уудмаас халихад

Оргил бүхний оргил нь нутгийн минь толгод л байж шүү дээ

2. Шүлгийн санаа, зохиолчын намтар, зургийг харьцуулан эргэцүүлэл бичээрэй

“АУЗ Т.Галсан нэгдүгээр ангийг муу, хоёрдугаар ангийг дунд, гуравдугаар ангийг сайн, дөрөвдүгээр ангиа онц дүнтэй дүүргэсэн тэрээр хичээлээ шүлэглэн бичдэг байжээ

...1960 оны эхээр үзэл сурталд харш, эсэргүү зохиол бичсэн хэмээн зохиол бүтээл нь хаагдаж “Эсэргүү” нэр зүүн цөлөгдсөн зохиолч юм. Ингээд тэмээчин, ямаачин, тууварчин, мужааны ажил хийж байгаад 1970 оноос мах комбинатад, хөргөх цехийн мастер, АПУ-д ачигч, МЗЭ-ийн хорооны дэргэдэх Нацагдоржийн музейд манаач, улмаар “Монгол кино” үйлдвэрт туслах ажилчин, баримтат киноны ерөнхий редактор, зургийн дарга, эдийн засагчаар ажиллажээ.”




Сэдэв: Зохиолын уран дүрслэлийг үнэлэх

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Аливаа хэлний үг олон салаа утгатай байдаг учраас үндсэн гол утгаасаа гадна өөр шилжсэн утгатай байдаг. Түүнчлэн ертөнцийн аль нэг үзэгдэл бусад юм үзэгдэлтэй зарим талаараа тун ойр төстэй байдаг нь үгийн энэ шилжсэн утгыг ашиглаж дүр дүрслэл бүтээх бололцоо олгодог

1. Сурах бичгийн 18, 19-р талд байх Ч. Дагвадоржийн “Шувуун зэл” шүлгийг мэдэрч уншаарай. Холбоос: <https://econtent.edu.mn/book/12rangi>



2. Шувуун сүрэг алс холоос ирж байгаа болохыг харагдах байдлаар нь ямар үгээр илэрхийлсэн бэ?
.....
3. Харагдах байдлаар нь илэрхийлсэн энэ үг уран дүрслэлийн ямар арга вэ?
А. Тойруулал Б. Хэтрүүлэл В. Адилтгал
4. “...Эрх багахан хүү минь, эрэг рүү битгий дөхөөрэй
Зовлоо чиг, жаргалаа чиг өнжин хонон тэмүүлсээр
Зорьж холоос ирснийх
Зоргоор, эх сайхан усандаа гунганаг...” хэмээх хэсэгтэй холбон амьтан бүхнийг хайрлаарай гэдгийг ээж нь хүүдээ хэрхэн ойлгуулсан бэ? Зохиолоос жишээ татан тайлбарлаарай.
.....
.....
.....
.....
5. “Ирж яваа шувуудын ганганааг сонсоход
Эхт хүний дотор цэлмэн уужирдаг юм
Эрт босож уяран зогсмоор санагддаг юм” шалтгааныг юу гэж бодож байна вэ?
.....
.....
.....
.....
.....

4. “бидэрлэнэ” хэмээх үгийн утгыг хам орчноос нь таамаглан тайлбарлаж дүрсээр илэрхийлээрэй

Дүрс	Тахийн зоо шиг бидэрлэнэ-хам орчны тайлбар

5. Тахийн зоо, тэнгэрийн заадас, туулайн гүйдэл зэрэг байгаль, ан амьтны онцлог шинж бүхий үгийн сонголтоос зохиолчийн....., зан чанар харагдахаас гадна бичлэгийн онцлог илэрчээ гэж үзэж болно.

- А. гярхай, ажигч
- Б. овжин, ухаантай
- В. хөдөлмөрч, тууштай

6. “...Хайрын хүчинд сэтгэл минь

Тэнгэрийн заадас шиг гэрэлтэнэ” хайрын хүчинд гэрэлтэж байгаа сэтгэлийг тэнгэрийн заадастай адилтгаж байгаа нь уншигчдад яаж нөлөөлж байгааг дүгнэн бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Сэдэв: Зохиолын дүрийг задлан шинжилье
Суурилах зохиол: С.Эрдэнэ “Өвгөн шувуу”

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дүр гэдэг бол ургуулан бодох бодлын хүчээр бүтээсэн гоо зүйн учир холбогдол бүхий тодорхойн зэрэгцээгээр нэгтгэн төлөөлсөн хүний аж амьдралын зураг мөн.

Тимофеев

Хэв шинжит дүр гэж юу вэ?

Түүхэн тодорхой үеийн хүмүүсийн гол нийтлэг зан төрх, нөхцөл байдлыг бүхэлд нь өөртөө агуулсан, зохиолын үйл явдалд идэвхтэй оролцож байгаа хүмүүсийг хэв шинж бүхий дүр гэнэ. Хэв шинжит дүр бол бүхэл бүлэг хүмүүсийн төлөөлөгч, ганц нэрээр нэрлэгдсэн олон юмны ерөнхий нэр юм.

1. С. Эрдэнэ “Өвгөн шувуу” өгүүллэгийг <http://mongolcom.mn/read/14870> анхааралтай, бүтээлчээр уншаарай.

2. “Жав гуай нар ханын толгойд тусаж байхад нүдээ нээлээ” монгол гэрийн наран цагийн хуваариар нар ханын толгойд тусах цагийг тооцоолж монгол малчин өвгөний сэрэх цаг мөн эсэхийг тайлбарлаарай.

Яагаад.....

3. “Жав өвгөний дүр сэтгэлийн баялгаараа өвөрмөц юм. Жав бол хар амиа бодох атгаг муу сэтгэлгүй хүн” гэдгийг зохиолоос жишээ татан батлаарай.

.....

4. Жав өвгөний бодол, ярианууд хаана өрнөж байгааг тодруулж, Ямар ялгаа гарч байгааг шинжилнэ үү.

Зохиолын хэсэг	Хаана?	Ялгаа
«Жав чи бvv бухимдаад бай» гэж өөртөө тушаав		
Гадаа болжмор жиргэж алсад адуу янцгаахад өөрийн эрхгvй сvvрс алдав		
«Хөөрхий дээ. Хvvгээ цэргээс халагдаж иртэл ганцаараа байх болох нь» гэж Жав гуай бодов		
Хөгшнөө зовоолгvй эртхэн шиг талийж одох юмсан гэж бодох болжээ		
Хэчнээн сайхан салж болмооргvй ертөнц		
Өвгөн шувуу буцна аа гэж...» гээд Жав гуай шvvрс алдсанаа тvрхэн зуурын гунигаа хөөн зайлуулж		
Жаран хэдэн жил дэлхийн тоос хөдөлгөж их юм үзлээ. Гомдол алга		

5. Байгаль ба юмсын дүрслэл дүрийг тодруулахад ямар үүрэгтэй орсныг тайлан тайлбарлаарай.

Дүрслэл	Жишээ	Үүрэг
Байгалийн дүрслэл	Наран хэвийж агь гангын үнэр анхилмал зөөлөн бөгөөд бүлээн сэвшээ үхлийн өмнө зоригтой тайван бай гэж аргадан илбэж байх шиг...	
Юмсын дүрслэл	Хоймрын авдар дээр хөгшний бадраасан зул гал дохиуртай хар цэцэг мэт бадамлан бөхөж байна.	

6. Дөрвөн өвгөний нийтлэг болон ялгаатай шинж юу вэ?

Өвгөдийн дүр	Ялгаатай шинж	Нийтлэг шинж
Дэвхрэг Жав	Хүнд өвчтэй, амьдралыг бясалган байгаа	
Гэээгт Найдан	Сайхан дуулдаг, нутгийн их хүндтэй хүн	
Шумуул Жамц	Өрөвч зөөлөн сэтгэлтэй	
Боргоцой Дорлиг	Дэгжин, шогч	

7. Зохиолч энгийн зүйлээс ургуулан бодож, бясалган тунгааж, дүрийн дотоод сэтгэлийн нарийн нандин руу өнгийн үзэж, уянгын аясыг зохих газарт нь шигтгэн, дүрийг амьдруулж чаджээ. Эдгээр дүрүүд бие биенээсээ ялгаатай байгаа нь дүрийн..... шинжийг, тухайн үеийн малчин өвгөдийн нийтлэг зан чанарыг өөртөө бий болгосон нь дүрийн талыг харуулж байна

- А. Бодит ба хийсвэр
- Б. Бодь гал ба хэв шинжит
- В. Адил ба төсөөт

Сэдэв: Зохиолын далд утгыг тайлан тайлбарлах

Суурилах зохиол: Л.Өлзийтөгс “Аквариум”

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

СЭДЭВ: Зохиогчийн амьдралын туршлагаас урган гарч, амьдрал түүнд хэлж өгдөг боловч зохиогчийн ухаан санаанд нэг хэсэгтээ эмх замбараагүй хаос байдалтай оршин байдаг боловч чухамдаа дүр болгон эвлүүлж бичих ажилд зохиогчийг өөрийг нь уриалан дуудаж байдаг тийм үзэл санааг сэдэв гэнэ.

- Тухайн бүтээлийн зохиогч хэн бэ гэдгээс шууд хамааралтай
- Биежсэн бодит зүйл бус анхдагч, хийсвэр санаа төдий зүйл
- Бүтээл бичигдэх болсон үндсэн шалтаг, шалтгааны нэг

1. Л. Өлзийтөгс “Аквариум” өгүүллэгийг <http://www.goolingoo.mn/index.php?c=3835> анхааралтай, бүтээлчээр уншаарай.
2. Зохиолч өнөөгийн Монголын нийгмийн амин чухал асуудлуудыг хэрхэн хөндсөнийг зохиолоос эш татан дэлгэрүүлэн тайлбарлаарай.
Ямар, ямар асуудал байж болох вэ? Зөв харгалзуулаарай.

1. Би угийн бачимдуу хүн

А. Албан тушаал

2. Нөхөр маань хорин жил үхэн хатан зүтгэж байж хүрсэн өндөрлөгөөсөө буув

Б. Хүүхэд хүмүүжил

3. 12 настай хүүхдэд баймааргүй хэвлүүн яриатай хүүтэйгээ би огт таардаггүй байсан юм л даа

В. Хувийн орон зайн

4. Нэгдүгээрт манай ээжийг авсан ах буцааж өгөөч!

Г. Гэмт хэрэг

5. Ах нар маань миний ханиас мөнгө нэхсэн гэнэ.

Д. Эмэгтэйчүүдийн эрх

6. Тэгээд ахин загас болохоор шийдээд байна.

Е. Гэр бүл салалт

3. Монгол Улсын хувьд авч үзвэл чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэнээр олон нийтэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шүүмжлэх эрх нээгдсэн ч эмэгтэйчүүдийн орон зайг үл ойшоосон хэвээр байгааг “Аквариум” зохиол харуулжээ. /Ш.Туяа/
Энэхүү тайлбарыг зохиолоос жишээ татаж батлаарай.

.....
.....
.....
.....
.....

4. Ээжийг алтан загас болгож, загасны хэл яриа, дуу авиагүй шинжийг сонгосны учрыг тайлбарлаарай.

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

5. Хоосон зайд тохирох үгийг нөхөөрэй.

Эмэгтэйчүүдийн дуу хоолой, үзэл бодол олон нийтийн бус, хувийн чанартай мэт байгааг зохиолын үйл явдал зөвхөн гэрийн давчидмал орон зайд өрнөж буйг аквариумаар илэрхийлжээ



Биет орон зай



Эмэгтэйн хүсэл нь хязгаарлагдмал шинжтэй байгааг илэрхийлжээ

“Монголын өргөн тал, дуусашгүй мэт үргэлжилдэг цэлийсэн уудам нутаг маань надад багадаад байгаа юм шиг санагдаад үргэлж л давчдаж явдаг байлаа”



.....



6. “Сэдэв гэдэг нь тухайн бүтээлийн зохиогч хэн бэ гэдгээс шууд хамааралтай бөгөөд бүтээл бичигдэх болсон үндсэн шалтаг, шалтгааны нэг” гэж үзвэл “Аквариум” өгүүллэгийн сэдэв юу байж болох вэ?

- А. Гэр бүл дэх харилцаа
- Б. Хүүхэд хүмүүжлийн
- В. Нийгэмд эзлэх эмэгтэйчүүдийн байр суурь

Сэдэв: Зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Тодорхой нэг зохиол олон тооны жижиг сажиг явдлуудаас бүрддэг тул тэдгээр явдал бүрд өөр өөрийн бичил сэдвүүд /хам сэдэв/ байхын зэрэгцээ бичил утгууд бүрэлдэн агуулагдаж байдаг. Уншигчид хам сэдвийг бүрэн ойлгосноор танин мэдэхүйн цэнгэл таашаалыг эдлээд зогсохгүй, тухайн зохиолын үнэт чанар нь нэмэгддэг. Хам сэдэв нь зохиолын далд санааг баяжуулдаг. Зохиолын хам сэдвийн тусламжтайгаар бид янз бүрийн цаг үе, өөр өөр соёлт нийгмийг танин мэддэг.

- Түүхийн хам сэдэв
- Соёлын хам сэдэв
- Нийгмийн хам сэдэв
- Шашны хам сэдэв
- Улс төрийн хам сэдэв
- Гүн ухааны хам

1. С. Дашдооров “Бууж мордох хорвоо” өгүүллэгийг <http://www.imedee.com/dashdoorov-02/> анхааралтай, бүтээлчээр уншаарай.

2. Яагаад “Бууж мордох хорвоо” гэж нэрлэснийг буух, мордох үйлтэй холбон тайлбарлаарай. Утга ойролцоо ямар үг байдаг вэ?

.....

3. “Ангаа өвгөн ингээд явчихдаг байж... Нутгийн нуруутай хэдэн өвгөний нэг байлаа даа...” гэж өгүүлсэнэ ийш тийш ямар нэг юм чимээ чагнаж бараа харж, сэлбэлзэн харснаа маанийн шад бувтнан уншив...”

- ямар нэг юм чимээ чагнаж бараа харах
- сэлбэлзэн харах энэхүү үйлд ямар утга байна вэ?

.....

4. Ганцаар овоон дээр сууж буй Төгөө өвгөн яагаад чимээ чагнаж, сэлбэлзэн харах болсон бэ?

.....

5. Төгөө өвгөний энэ үйл тухайн үеийн нийгмийн байдалтай холбоотой болов уу? Яагаад?

.....

6. “... Бид тэнд сүүлийн удаа хөөргөө зөрүүлэх учиртай байж дээ ... ” гэж харууслаа илэрхийлэн үглэж, Хангай өвгөнийг хvндэтгэн явдаг сэтгэлээ нээн мориноосоо буужээ...” энэхүү хэсгээс жинхэнэ монгол хүн болохыг юугаар баталж болох вэ?

.....
.....

7. Бууж мордох хорвоод зөв амьдрахын утга учрыг ийнхүү томьёолжээ. Энэ хэн болохыг нөхөж бичнэ үү.

Түмэнд нүүрийн буянтай	+	Төрийн нуруу төвшин	+	Малд нүдтэй	=
---------------------------	---	------------------------	---	-------------	---	-------

8. Дээрх гурван ойлголт монгол хүний үзлээр бол ижил түвшний шалгуур ажээ.

Түмэнд нүүрийн буянтай – *хариу нэхдэггүй тусч*

Төрийн нуруу төвшин – *хариуцлага алддаггүй түшигтэй*

Малд нүдтэй -..... гэдгийг суурин соёлын үүднээс юутай адилтган тайлбарлаж болох вэ? Яагаад?

.....
.....
.....
.....

9. “... Сад өнөө олон ногт чагтаа арц унгатган ариулж ёслоод өврөөсөө урт цэнхэр хадаг гаргаж “За Хангай минь, ууган унагыг минь уургална даа ... гэснээ амыг нь тvvн рvv харуулан хандав...” гэсэн хэсэгт ямар, ямар ёс заншил байна вэ?

.....
.....
.....
.....
.....
.....

10. – Сад минь юу гэсэн үг вэ? Хvv чинь байна, хvргэн чинь байна Цаадуулынхаа нэгээр уургалуул ... Адууны чинь эзэн гомдоно ...” гүү барих монгол соёлыг харуулсан хэсэгт Ангаа өвгөний ямар зан чанарууд харагдаж болох вэ?

.....
.....
.....
.....
.....

Дасгал 2. “Нүүдэлчин монголчууд байгалийн элдэв юмс үзэгдлийн холбоо хамаарлыг соргоогоор ажиглан, түүнийгээ эргэцүүлэн дүгнэж цаг агаарын өөрчлөлтийг ч урьдчилан шинждэг уламжлалт арга ухаантай юм” гэсэн нүүдэлчдийн соёлын хам сэдэв зохиолд хэрхэн туссаныг эргэцүүлье.

Алхам 1. “Бие чилээрхэж, бие хүндэрлээ” тэнгэр яахын шинж гэж ярьдаг вэ? Зохиолоос жишээ татан тайлбарлаарай.

.....
.....
.....

Алхам 2. Зүгийн бэлгэдлээр цаг агаарын байдлыг шинжиж буйг зохиолоос жишээ татан тайлбарлаарай.

.....
.....
.....

Алхам 3. Хэсэг бүрийн утгад дүйх хэлцийг гүйцээн бичээрэй

- Үнэндээ тэр чоно маш хашир, дээрээ ишиг хурга майлалдан тонгочин тоглоход идэхийг бодохоосоо илүү “За энэ ч яамай!” гэж бодон уг мухартаа шигдэх бөгөөд, ер нь ан эргүүлэхдээ хажуу хавиргаа хадрахыг цээрлэнэ.

..... үүрэндээ

- “Хаа нэгтэйгээс өлсгөлөн хоёр хон хэрээ гарч ирээд дээр нь эргэлдэв. “Хон хон” гуагалах нь: “Хөөе хөөе, энд ойрхон амтат зууш хүлээж байна шүү” гэж байгаа нь тэр аж.

.....шороо. хэрээ

- “Одоо удахгүй түр зуурын ширүүн бороо орох нь лавтай. Ээ дээ энэ далим анд гарваас ам тосдох олз ч аяндаа шүү дээ!” гэж бодов.

.....самбаанд. бороонд

Алхам 4. “Төлгөн хонины ясыг нь тойруулан зулгаасан атал гүйцэд идсэнгүй” ямар насны чоно байж болох вэ? Яагаад?

.....
.....

Алхам 5. “Ер нь хоёр чоно нэг малыг дундаа идэхдээ бие биеэс өрсөн ухаангүй шомбоддог байтал тэр төлгийг хоёр чоно цээж бөгсөөр нь хуваан тун аятай идсэнийг үзэхэд”

Энэ хоёр чонон онцлог юу вэ?

.....
.....

Дууссан:онсарөдөр

Сэдэв: Зохиолын гадаад ба дотоод орчныг шинжлэн, дүрийн зан төрхөд нөлөөлж байгааг үнэлье

Суурилах зохиол: Д.Намдаг “Хөгшин чоно ульсан нь”

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Тухайн зохиолыг уншихдаа зохиол бол бидний амьдралтай зэрэгцээ шугаманд оршиж буй бас л нэг амьдрал гэдгийг мэдэрч ойлгох хэрэгтэй.

Зохиолын гадаад орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох

1. Байгаль, цаг уурын байдал нь дүрийн сэтгэл зүйд нөлөөлж байгааг
2. Зохиол дахь нөхцөл байдлын онцлог нь дүрийн давуу ба сул талыг илэрхийлж байгааг
3. Орчны өөрчлөлтөөс дүрийн бодол санаа, үйлдэл, үзэл бодол өөрчлөгдөж байгааг
4. Орон цагийн орчны дүрслэл нь дүрүүдийн хоорондох харилцааны таатай ба таагүй уур амьсгалыг тодруулж байгааг

Зохиолын дотоод орчин дүрийг тодруулахад нөлөөлж байгааг шинжлэх:

1. Дүрүүдийн хоорондох сэтгэл зүйн уур амьсгал зохиолын аль хэсэгт тод ялгарч байгааг
2. Зохиол дахь нөхцөл байдлын онцлог нь дүрийн давуу ба сул талыг илэрхийлж чадаж байгааг
3. Гол дүрийн дотоод бодол, сэтгэл зүйн өнгө аяс нь \ гунихрал, санаашрал, цөхрөл, шийдэмгий байдал\ нь бусад дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг
4. Дүрийн сэтгэл зүйн байдлаар илэрч буй зан төрхийн өвөрмөц чанар амьдралын утга учрыг нээхэд нөлөөлж байгааг гэх мэтийг тодруулж унших.

Дасгал 1. Гадаад орчин - Байгаль, цаг уурын байдал нь дүрийн ямар шинжийг тодруулж байгааг судалж уншъя.

Алхам 1. Зохиол дахь гадаад орчны дүрслэл ямар чонын дүрийг тодруулж байгааг харгалзах нүдэнд (+)-ээр тэмдэглээрэй

Гадаад орчин	Залуу чоно	Хөгшин чоно
<i>одоо ид зуны халуун боловч эрт цагийн байдлаар хэл гарган аахилуулах халууныг үзсэнгүй.</i>
<i>Доод газар тэс хөлдүү, халуун биеийг хайрах таширамд сэвэлзэх салхи цантсан цээжсний сорыг эрвэлзүүлэн хөдөлгөнө.</i>
<i>чийг даасан хөндийнхөө мухраас сугаран гарав.</i>
<i>эгц цавчим ирмэгт нь орогноод</i>
<i>өвөр энгэрт нь хоргодох</i>

Алхам 2. Яагаад сонгосон үндэслэлээ тайлбарлаарай.

Жишээ нь: Ид зуны халуун нь хөгшин чонын сул дорой байдлыг илүү тодруулсан учир нь урин дулаан цаг гэдэг бол байгалийн шалгуур багатай цаг үе юм.

- Тэс хөлдүү газар, сэвэлзэх салхи.....
- Чийг даасан хөндий.....
- Эгц цавчим ирмэг.....
- Өвөр энгэр.....

Алхам 3. Улирал болон цаг уурын байдал нь ямар насны чоныг илэрхийлж энэхүү гадаад орчин нь түүний ямар шинжийг нь илүү тодруулсныг дүгнэн бичээрэй.

Энэ шөнийн жавар маш их, түүний аясаар тэнгэрт гялалзах одод нүдний нь өмнө байгаа мэт тусна.

.....
.....
.....
.....
.....
.....

Гагцхүү өнөөдөр үдээс хойш ашгүй нэг бие тавигдан халуун болсон боловч, агаар хүндрэн бугчимдэж, унтаж амрахад нь багагүй саад болсон байлаа

.....
.....
.....
.....
.....
.....

Өвлийн идэр ес дундаа гялалзаж байх үеэр ар хойд зүгээс ардаа арван хэдэн омог чоныг дагуулсан...

.....
.....
.....
.....
.....
.....

Алхам 4. Зохиолч “мэл цагаан тал” гэсэн дүрслэлийг давтамжтай ашигласан нь юуг илэрхийлэх гэсэн бол?

*...нимгэн цасанд хучигдсан **мэл цагаан тал** залган авахад сая зогслоо.*

*Тэрээр өмнөх тулалдааныг ажигж байснаа гэнэт хаян **мэл цагаан тал руу** харайлгав.*

*...түүний оронд **мэл цагаан тал** цэхэлзэн цэлийж, өдөр дундын нар нүд царгин гялбуулна.*

*Дулаан хайрханы хүү **мэл цагаан талын** дунд гав ганцаараа болж, гэлдрэх шогших хоёрын хооронд сажилсаар өдрийг авав.*

.....
.....
.....
.....

Дасгал 2. Дотоод орчин - Дүрүүдийн хоорондох сэтгэл зүйн уур амьсгал зохиолын аль хэсэгт тод ялгарч дүрийн зан төрхөд хэрхэн нөлөөлж байгааг үнэлье.

Алхам 1. “Хөгшин чоно сэтгэлдээ “Ээ дээ энэ бороо, идишийг бидэндээ эрхгүй хайрлана бий” гэж бодно. Хажууд нь азарган чоно: “Үгүй энэ хар борооноор ингээж явахын хэрэг юу вэ.” гэсэн хэсгээс санаа авч дараах зураглалд тайлбар бичээрэй.

Хөгшин чоно=Цэрэнчимэд



Азарган чоно=Залуу малчид

Тайлбар:
.....
.....
.....

Алхам 2. Тэдний зан байдлыг зураглалд тохируулж нэг үгээр илэрхийлээрэй.

Хөгшин чоно=Цэрэнчимэд



Азарган чоно=Залуу малчид



.....

.....

Алхам 3. *Гайтай тэр хавхнаас хөлөө авах гэж үй түмэн үйлээ үзсэний эцэст хүн ирэхийн бараанаар тэр хөлөө тас хазаж үүрд догolon хоцорчээ”*

“Хөгшин чонын эцэг түүнийг ирээдүйдээ үр хүүхдүүдэд минь аюултай хурдан морь болно гэж үзээд ... унага ахуйд нь хонгыг нь сэт хазсан” гэсэн зохиолын хэсгээс санаа авч онч мэргэн үг /афоризм/ зохиогоорой.

.....
.....
.....

Дууссан:онсарөдөр

Сэдэв: Зохиолын сэдэв, утга санааг тодорхойлох
Суурилах зохиол: Д.Намдаг “Хөгшин чоно ульсан нь”

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Сэдэв, зохиолчоос тухайн зохиолыг бичих болсон үүдэл санааны товлогдсон хэлбэр, бичиж туурвихын шалтгаан нь мөн. /Сэдэв зохиол бичигдэхээс өмнө зохиолчийн сэтгэл санаанд бий болдог/ Энэхүү тов төдий атлаа гүн бүтэцдээ өргөн агуулгыг хураасан амьд үйл явцын цогцолбор ойлголтыг сэдэв гэнэ. Товчоор хэлбэл ХҮН-БАЙГАЛЬ-НИЙГМИЙН тулгамдсан, хурц чухал асуудлыг хөндөж түүгээрээ зохиолчийг зохиол бүтээл туурвихад өдөөн дуудаж байгаа хүчин зүйл юм.

Тухайн бүтээлийн зохиогч нь хэн бэ? гэдгээс шууд хамааралтай түүнээс шалтгаалж байдаг буюу зохиогчоосоо хараат шинжтэй

Биежсэн бодит зүйл бус харин анхдагч, хийсвэр санаа төдий зүйл

Тухайн зохиол бүтээл бичигдэх болсон үндсэн шалтаг, шалтгааны нэг

Олон жижиг бичил сэдвийг нэгтгэсэн гол сэдэв зохиолд байдгийн адил уран сайхны бичвэр /зохиол/-т олон жижиг салбарласан утгыг нэгтгэсэн нэг гол төв утга байна. Зохиолд үйл явдлаар дамжин шууд илрэх **ил утга**, тэрхүү утгын гүнд зохиогчоос зориуд шингээсэн, эсвэл бичвэрт аяндаа хуран цогцолсон нуугдмал **далд утга** байна.

Дасгал 1. Зохиолын үйл явдлыг загварчилж ойлгох нь сэдвийг тодруулах, далд санааг тайлан тайлбарлах нэг арга байдаг тиймээс зохиолыг загварчилж ойлгоё.

Алхам 1. Дараах тулгуур бичиглэл, зураглалыг зохиолын үйл явдалтай харьцуулж яагаад ийнхүү үзүүлснийг таамаглан тайлбар бичээрэй.



.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Алхам 2. Дараах хэсгүүдийн ижил утга нь юу вэ?

“За одоо төрсөн өссөн нутаг минь хаа билээ?” гэх мэт толгой өргөн эргэн тойрныг ажиглав.

Тэндээс Дулаан хайрханы хүү эм юугаа дагуулан өөрийн тааваар өнжсин хонон явж өсөн төрсөн нутагтаа эсэн мэнд хүрчээ.

Иймд мань хөгшин дутуу идэн, өлөгчинтэйгөө уулынхаа зүг яаран зүтгэв.

.....

.....

Дасгал 2. Эрт дээр үеэс өвгөдийн сургаалаа дагаж, ахмадын үгийг сонссоор ирсэн нүүдэлчдийн уламжлал зохиолд хэрхэн илэрч байгааг үнэлж дүгнэе.

Алхам 1. /сонор сэрэмж, хашир ухаан, ажигч гярхай/ зан төрхийн онцлогт тохирох үгсийг нөхөж бичээд хэсгүүдийн утга санааг тунгаан бодож “ИТГЭЛ” сэдэвт богино хэмжээний эргэцүүлэл бичээрэй

Үгүй, идсэн даруйд нь хөөхөөр юу ч болдоггүй идсэнээ амаараа гаргаж орхиод гүйцээгдэхгүй болдог гэнэ. Гурав дахь хоног дээрээ л идсэн нь ид шингэж яаж ч чаддаггүй дээрээ байдаг байх.

-За энэ ч мөн Цэрэнчимэдийн үг байна. Үнэнч юм уу, худлаа ч юм уу хэн мэдлээ. Аягүй бол унаа морьдын чинь гарз болж магадгүй л байх.

Ахмад малчин Цэрэнчимэдийн-д итгээгүй анчид хөгшин чонын ухааныг гүйцээгүй



Эл яриан дундуур гадаа нь өлсгөлөн муу хар гичий онц сонор сайтайгаараа алс ууланд чоно улихыг сонсоод хар яр хуцав. Ухаандаа тэр, “Хүүе! Хүүе! Тэнд чоно улж байна шүү, та минь мэдээрэй” гэж бусад нохдод мэдээ хүргэх гэсэн хэрэг байлаа. Гэтэл гэрийн эзэн:

-Үгүй, энэ муу гичий гэв гэнэт хий хуцдаг өлөгчин шүү. Аль вэ хө гараад нэг сайн тас цохиод орхиоч! гэв.

Тэжээсэн нохойнхоо-д итгээгүй малчин ойрхон чоно байгааг мэдээгүй



Яльгүйхэн осолдлоор ямар ч аюул хүрч болдгийг хөгшин чоно тун сайн мэднэ. Гэтэл залуу азарган чоно дотроо “үгүй ер яасан удаан явна вэ. Ингэж явснаар бид хэзээ юугаа олж идэх билээ” гэж бухимдана.

Хөгшин чонын-д итгээгүй залуу чоно амь эрсэддэг



Итгэл

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Дууссан:онсарөдөр

Сэдэв: Зохиолыг уншиж, хам сэдвийн хүрээнд эргэцүүлэн
хүний мөн чанарыг ойлгох
Суурилах зохиол: Ч.Галсан “Аянгат цагийн тууж”

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Чинагийн Галсан: “Аянгат цагийн туужийг анх Герман хэл дээр бичсэн. туужаараа би дэлхийн утга зохиолын хаалгыг дэлдээд орчихсон юм. Дэлхий утга зохиолд элссэн миний дипломын ажил гэж хэлж болно. 27 настай байлаа. Яг л өөрийнхөө сонссон, харсан, уйлсан нулимсныхаа тухай бичсэн” гэсэн зохиогчийн ярианаас үзвэл энэхүү туужид нийгэм, соёл, түүх, намтрын хам сэдэв илрэх ажээ.

Дасгал 1. Зохиолыг уншихдаа зураглал болон тулгуур бичиглэл хийж тэмдэглэх нь утга санааг сайн ойлгох, ой санаандаа удаан хадгалах нэгэн том боломж байдаг.

Тиймээс зохиолоо уншихдаа тулгуур бичиглэл хийгээрэй.

Алхам 1. http://newera.edu.mn/en/course/material/3465/pdf_content Зохиолоо уншаад дараах тулгуур бичиглэлд тохирох нэг өгүүлбэрийг зохиолоос юм уу өөрийн үгээр бичээрэй.

Жишээ нь:

Залуу хархүү-тэмээчин Жанибек → чонын ав

... Бодвол тэмээчин хөгшинийг араатан чоно авлах чадалтай гэж итгэх амьтан надаас өөр даанч байгаагүй юм байлгүй...

Жанибек-Оргодол → цуурхал

... Жанибекуыг алуурчин гэж нутаг даяараа цуурч, хүн бүхэн зай барьдаг...

Жанибек-Баянак → дурсамж

... Энд амьдрал нь дууссан Баянак гэдэг чинь Доёбуугийн биш миний ганц хүү байсан юм...

Доёбуу-Суяш → харилцаа

... Жанибекын хайртай бүсгүй Суяшыг Доёбуу хөрөнгөд нь шунаж, булаан авсан...

Жанибек-Суяш, Баянак → нэр хүнд

... Нэр хүндээ алдахаас айж хайртай эхнэр хүүгээсээ зайгаа барьдаг... **ГЭХ МЭТ ЦААШ**

үргэлжлүүлэн тэмдэглээрэй

Жанибек → албан тушаал

Баянак → эр бяр

Суяш → нас барав

Жанибек-Баянак → эцэг, үр

Баянак → цэрэг

Баянак → орголт

Жанибек Баянак → уулзалт

Баянак-Тунсаг → тус

Жанибек → мөрдөлт

Баянак → ялалт

Жанибек → эмнэлэг

Доёбуу → мэдүүлэг

Баянак-Довай, Гумай → харилцаа

Баянак → буудуулав

Жанибек → тэмээчин

Гумай → эрэл

Жанибек → сорви

Баянак → овоо

Жанибек → салсан өдөр байхад уулзах өдөр бий

Нийгмийн хам сэдэв - Зохиолд нийгмийн байгууллын онцлог хэрхэн туссан хийгээд тухайн үеийн нийгэм цаг үед амьдарч байгаа эрх мэдэлтэн, жирийн хүмүүсийн харилцааны онцлогийг судалж унших

Алхам 1. “Аянгат цаг” гэж ямар цаг үеийг хэлж байна вэ? Хариултыг сонгосон шалтгаанаа бичнэ үү.

A. Жанибек өвгөн дурсамжаа ярьж буй одоо цагийг

Яагаад?.....

B. Зохиолын гол үйл явдал өрнөж буй өнгөрсөн цаг үеийг

Яагаад?.....

B. Өнгөрсөн болон одоо хоёр цагийг

Яагаад?.....

Алхам 2. Дараах жишээнүүдээс тухайн үеийн нийгэм хүн зоны амьдрал, оюун санаанд ямар нөлөө үзүүлдэг байсан юм шиг санагдаж байна вэ? Жишээ бүр дээр шалтгаан бичээрэй.

Хөрөнгөтэй хөрөнгөгүй хоёр байдаг хөрөнгөгүй нь хөрөнгөтэйгөө устгах ёстой гэж мэдэж авлаа.

Эхнэр аваагүй л юм ... Ухаандаа царай зүсний сайхантай хөөцөлддөггүй юмаа гэхэд намтай нэг нь номгүй, номтой нь намгүй байсан жишээтэй.

Хүү минь чамаас л болж би намаа хуурахад хүрэв гэж бодох үе ч байдаг байв.

Алхам 3. Хувьсгалч Жанибек, хайртай бүсгүй-Суяш, өөрийн хүү-Баянак хоёроо эргүүлэн авч чадахгүй байсан нь юунаас болсон гэж бодож байна вэ? Зохиолоос жишээ татан дүгнээрэй.

Жанибек: “*Үүнийг би өөрөөсөө гучин жил асуугаад хариу олохгүй яваа юм*”

Соёлын хам сэдэв - Зохиолд тухайн үндэстний хүн зоны ахуйн болон оюуны ямар соёл тусгагдсан, тэдгээр нь ямар үг хэллэг, өгүүлбэрээр илэрч утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг судалж унших

Алхам 1. *Байгаль дэлхийдээ анхаарлаа хандуул. Байгаль бол амьдралын эхлэл. Нүүдэлчид байгальтайгаа хамгийн ойр байж, дасан зохицож амьдардаг. Тиймээс нүүдэлчдийн хүч гайхамшигтай. \МУСГЗ, зохиолч Ч. Галсан* Яагаад ингэж тодорхойлсныг дараах хэсгүүдээр баталж бичээрэй.

Ингэж амь гарангуут зах хязгааргүй ээрэм талд газрын холыг зорьж эх нутагруугаа саргүй шөнөөр алтан гадсаар чиг баримжаалан гүйжээ.

Шатаах нь шив дээ гэж намайг хэлбэл цуг яваа нөхөр минь болох нэгдлийн тэмээчин Жанибек өвгөн: “Гайгүй ч биз. Харин ч аадар асгаж, араас нь цас орж байх бий” гэлээ.

...Тэгснээ сөхрөн сууж аргалыг зэрэглээд алган завсраа хомоол үржэ голд нь овоолоод, өврөөсөө чүдэнз гаргаж алгаараа салхи хаан зураад нунтаг хомоолд дөхүүлэн барив ... Гал дүрэлзэн аслаа.

Гал түлж, үлдсэн аргалыг агуйн мухарт шовойтол овоолж орхив. Хэн ч, ямар ч цагаар ирсэн аваад түлэхэд бэлэн байг.

Намтрын хам сэдэв- Зохиол дахь зарим утга, үг хэллэг, өгүүлбэр, эхийн хэсэг зэргийн утга нь зохиолчийн намтартай холбоотой болохыг судалж унших.

Алхам 1. Зохиолд гарах газар усны нэрс нь ихэвчлэн юуны нэрс давамгайлж байгаа болоод үгийн гарлын талаас ажиглан дараах таамаглалыг нөхөөрэй.

Таван Богд, Цагаан Асга, Арцатын Хамар, Цагаангол, Баянгийн даваа, Хара-Хоов, Оруктуг, Хара-Адыр, Боргасун, Бугту-Гириш, Буга-Жар, Дестигийн хяр, Теректийн нуруу

Эдгээр нь ихэвчлэн-ы нэрс байгаагаас үзвэл зохиолч уулархаг өндөрлөг газрын хүн болохыг таамаглаж болно. Үгийн гарлын талаас ажиглавал Тува үгс байна. Иймээс зохиолч ястан байх магадлалтай. Эдгээр ястнууд аймгийн суманд ихээр суурьшин амьдардаг учраас зохиолч энэ нутгийн хүн байж болох юм.

Зохиолчийн ярилцлагыг уншиж өөрийн таамгаа бататгаарай.

https://tagtaa.mn/enkhtsolmon/1?fb_comment_id=1830412370417703_1946358155489790 холбоосоор орж зохиолч Ч. Галсангийн “100 жилийн дараах зохиолч” ярилцлагыг уншаад дараах асуултад хариулаарай.

1. Ярилцлагыг яагаад 100 жилийн дараах зохиолч гэж нэрлэх болов?

.....

.....

2. Халх Монгол хэлээрээ муухан ярьдаг хүүхэд Герман хэлийг богино хугацаанд амжилттай сурсан шалтгаан нь юу байв?

.....

.....

3. Чи энэхүү ярилцлагыг уншсаны дараа Монголыг мэдэхгүй хэн нэгэн хүнд Монгол орноо гурван зүйлээр тодорхойлбол?

.....

.....

Түүхийн хам сэдэв- Зохиолд түүхт хүмүүс, түүхэн үйл явдал, он цаг, газар ус зэрэг нь хэрхэн дурдагдаж үйл явдал, утга санаа, дүрүүдтэй яаж холбогдож байгааг судалж унших

Алхам 1. Зохиолд гарах эдгээр он тоололд Монгол улсад ямар түүхэн үйл явдал болсныг зөв холбоорой.

1921 он

1930-1932 он

1939 он

Дайн

Хувьсгал

Хамтрал

Алхам 2. 1921 он манай бөглүү хязгаарт их шуурга шиг сүртэй бус, үүрийн гэгээ шиг зугуухан иржээ. “Бөглүү хязгаар” гэж одоогийн аль аймаг вэ?

.....

Алхам 3. Жанибекийн харц гал дээр тогтжээ. Тэрхүү байдал нь хоёр эриний босгон дээр ертөнцийн энэхэн алс бөглүү хязгаарыг донсолгосон шуурган жилүүдийн дүр зураг дөлөн дотроос түүний нүднээ амилан харагдаж байна уу даа гэсэн бодол төрүүлнэ.

“Шуурган жилүүд” гэж хэдээс хэдэн оныг хэлж байна вэ?

.....

Алхам 4. Дайны үеийн тухай би чамд шинэ юм юу ярилтай билээ, ном сэлт өдий төдий гарлаа шүү дээ.

Хаана болсон дайн бэ?

.....

Алхам 5. Зохиолд ямар түүхэн хүмүүсийн нэр гардаг вэ? Тэдгээр хүмүүс нь ямар түүхэн үйл явдалтай холбоотой вэ?

.....

.....

Дууссан:онсарөдөр

Сэдэв: Зохиолын **өгүүлэгдэхүүн**, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэх
Суурилах зохиол: Ч.Галсан “Аянгат цагийн тууж”

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Өгүүлэгдэхүүн- Зохиол бүтээл гэгч нь нэг талаас утга-сэдвийн цогц байсан бол өөр нэг талаасаа хүн болон эд юмсын үйл хөдөлгөөний үргэлжилсэн цуваа мэт юм. Зохиолын энэ үргэлжилсэн их цуваа хөдөлгөөнийг үг хэлээр илэрхийлдэг бөгөөд тэр нь зохиолын өгүүлэгдэхүүн юм.

Өгүүлэгдэхүүний нэгж- эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал

Дасгал 1. Өгүүлэгдэхүүн гэдэг нь хүн ба эд юмсын үргэлжилсэн их цуваа хөдөлгөөний илэрхийлэл байдаг. Тиймээс зохиолд өгүүлэгдэх цаг уурын хувирал, үргэлжилсэн цуваа хөдөлгөөн дүрийн сэтгэл зүйтэй хэрхэн холбогдож байгааг тодруулж уншъя.

Алхам 1. Байгалийн үзэгдлийн зүй тогтол болон зохиолд өгүүлэгдэх эрэмбээр, зөв дарааллыг тогтоож дугааралана уу.



Цас зогссоны дараа салхи үе үе сэвс хийн босч жигтэйхэн хүйтрэв.



Дүлий цагаан тэнгэрээс том ширхэгтэй цас нүүр нүдгүй асгарна.



Аадрын хөг нэгэнт өнгөрч оронд нь шиврээ бороо нэг хэмээр шивнэн орж, дэлхий зүүрмэглэж эхэлжээ.



Цас орсоор л байна.



Одоо нар шарж байгаа ч удалгүй аадар асгаж, араас нь цас орж байх бий.



Цас хаялж эхэллээ.



Цас нар жаргахын үед сая л зогсов.



Аянга цахилж байна

Алхам 2. Дараалалд оруулсан шалтгаанаа тайлбарлан бичээрэй.

Үлгэрлэвэл:

1. “Одоо нар шарж байгаа ч удалгүй аадар асгаж араас нь цас орж байх бий”

Зохиолын эхлэл хэсэгт гарах энэхүү өгүүлэмж нь цаг агаарын байдлыг цааши яаж өрнөхийг таамагласан шинжтэй учир эхэнд байна.

2. **Аянга цахилж байна-** Халуун уур амьсгал хүйтэн болж хувьсаж байгааг илтгэх бөгөөд цааши ямар үзэгдэл болохын урьтал

3.

4.

5.

6.

7.

8.

Алхам 3. Дараалалд оруулсан хэсгээ харгалзах өгүүлэгдэхүүний нэгжүүдтэй нь холбоорой.

Дүлий цагаан тэнгэрээс том ширхэгтэй цас нүүр нүдгүй асгарна.

Аадрын хөг нэгэнт өнгөрч оронд нь шиврээ бороо нэг хэмээр шивнэн орж удалгүй цас хаялж эхэллээ

Цас нар жаргахын үед сая л зогсов.

Одоо нар шарж байгаа ч удалгүй аадар асгаж, араас нь цас орж байх бий.

Аянга цахилж байна

Цас зогссоны дараа салхи үе үе сэвс хийн босч жигтэйхэн хүйтрэв.

Эхлэл-Бороо, цасны тухай өгүүлэгдэх өрнөлийн сүүр, дэвсгэр

Зангилаа- Байгалийн ямар үзэгдэл болж өрнөх бол? гэсэн асуулт дагуулсан, үргэлжлэхийн шалтгаан

Өрнөл- Энэ үйл явдлын гол шинжийг тодруулсан хэсэг

Туйл- Энэ үзэгдэл тултал хурцдаж, дээд цэгтээ хүрч очихыг хэлнэ.

Тайлал- Байгалийн үзэгдэл жам ёсоороо хэрхэн тайлагдаж байгаа хэсэг

Төгсгөл- Энэхүү үзэгдэл цаашид юу болж төгссөнийг тодруулсан хэсэг.

Алхам 4. Өгүүлэгдэхүүний нэгжээр тодорхойлсон байгалийн үзэгдлүүд нь зохиолын аль хэсэгт ямар үүрэгтэй орсныг тодруулах асуултад хариулаарай.

1. *“Шатаах нь шив дээ гэж намайг хэлбэл цуг яваа нөхөр минь болох нэгдлийн тэмээчин Жанибек өвгөн: “Гайгүй ч биз. Харин ч аадар асгаж, араас нь цас орж байх бий” гэлээ”*

Өгүүлэгчийн ярих дурсамжтай энэхүү цаг агаарын байдлыг холбоотой гэж үзвэл ямар мэдээллийн дэвсгэр байж болох вэ? Таатай юу? Таагүй юу? Яагаад?

.....
.....
.....
.....
.....

2. *“...бүр яг “хорин тав” гэж мэдэж байдгийн учир юуных билээ?! “Яасан юм?” гэж би тэсэлгүй асууж орхив. Жанибек дуугарсангүй. Аянга цахилж, хөхөлбөр гэрэлд нь магнай дахь сорви нь гялсхийв”*

Тэнгэр дэх цахилгаан, магнай дахь сорви хоёр юуны нууц зангилаа болов?

.....
.....
.....
.....
.....
.....

3. “Цас хаялж эхэллээ ... Баянакийг хүлэг морь нь бус, сумтай буу, даалгавартай эрс, шийтгэл хүлээж тэр шийтгэл нь үхэл гэсэн үг ч байж мэдэх байв”

Саяхан нар шарж, аянга цахилж, аадар асгаж байсан тэнгэр. Одоо цас орж эхлэх. Саяхан цэрэгт мордож, гавьяа байгуулж, бага дарга болж байсан Баянак. Одоо оргодол болсон байгаа нь амьдралын өрнөл ямар шинж чанартайг харуулж байна вэ?

.....
.....
.....
.....

4. ...Тэгээд л онилсон бууныхаа гохыг дарж орхиж дээ, битгий л цаашаа яриасай гэж бодохдоо. “Цас орсоор л байна” гэлээ.

Аав, хүү хоёрын зөрчил туйлдаа хүрэхдээ “Яв даа, гэхдээ л хуулиас мултрах зам байдаггүй юм даа, бор туулай минь” хэмээн хэлж, гаргасан эцгийн шийдвэр зөв байв уу? Яагаад?.....

.....
.....
.....
.....

5. “Дүлий цагаан тэнгэрээс том ширхэгтэй цас нүүр нүдгүй асгарна ... Буун дуу хол ойрын хаданд цуурайтах нь том жижиг олон буугаар хэд дараалан буудах шиг дуулдав. Баянак эгээ л мөчир шилмүүс нь гүйцсэн лут өндөр хар мод шиг унасан юм. Алтайн хүрэн улаан буга шиг цусан дотроо хэвтэж байв”

Аянга цахилсны зангилаа нүүр нүдгүй шавхуурдах цас орсноор тайлагдав. Магнай дахь сорвины зангилаа үрээ хөнөөсөн эцгийн их гунигаар тайлагдав. Жанибек өвгөний туулсан амьдралаас үндэслэн “СОРВИ” сэдэвтэй эргэцүүлэл зохиогоорой. /шүлэг байж болно/

.....
.....
.....
.....
.....

6. Цас нар жаргахын үед сая л зогсов ... Хэд хоноод миний бие ахиад л унасан шорооноосоо тасран одлоо. “Салсан өдөр байхад уулзах өдөр бий” гэж Жанибек гуай хэлж билээ. Тийм үгэнд итгэж явах хэрэгтэй юм.

Жанибек өвгөн бодит дүр ажээ. Харин “Хэд хоноод миний бие ахиад л унасан шорооноосоо тасран одлоо” Тэр хэн байв? “Зуун жилийн дараах зохиолч” ярилцлагаас санаа авч таамаглаарай

.....
.....
.....

Сэдэв: Зохиолын өгүүлэгдэхүүн, **зохиомжийн** нэгжүүдийг
ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэх
Суурилах зохиол: Ч.Галсан “Аянгат цагийн тууж”

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Зохиомж- Зохиомж бол агуулгат хэлбэр. Өөрөөр хэлбэл зохиолын хэлбэрийн талын ойлголт буюу уг зохиол хэр уран санаагаар илэрч байна вэ гэдгийг тодруулдаг зүйл юм.

Зохиомжийн нэгж

Хүүрнэл- Зохиолч өөрөө, эсвэл хөндлөнгийн өгүүлэгчийн хэл яриагаар зохиолын үйл хөдөлгөөний дэс дарааг гаргахыг хэлнэ.

Харилцан яриа- Хоёр ба түүнээс дээш баатруудын хоорондын яриагаар тэдний зан төрх, амьдралын нөхцөл байдлыг илрүүлэн гаргасныг хэлнэ. Үргэлжилсэн үгийн зохиолд өргөн хэрэглэгдэхийн зэрэгцээ, жүжгийн зохиолд дүрслэлийн гол арга болно.

Тодорхойлол- Баатрын зан төрх, онцлог шинжийг өөрийнх нь үгээр илэрхийлэн гаргасныг тодорхойлол гэнэ.

Зохиолчийн тэмдэглэл- Хэрэг явдлыг тодруулах, тайлбар хийх, баатрын зан төрх, онцлог шинжийг нэмэн тодруулж тайлбарлах үүднээс зохиолын тодорхой хэсэгт хийх нэмэлт бичвэр юм.

Үглэл яриа- Дүрийг тодотгож байдаг, ямар нэгэн хариу шаардахгүйгээр өөртөө юм уу бусдад хандан хэлсэн, нэг талын ганцаарчилсан яриа.

Хөрөг дүр- Энэ нь зохиолын баатрын зүс царай, хэлбэр галбир намба төрх, хувцас хунар, үйл хөдөлгөөн, өвөрмөц араншин, сэтгэл санааны байдал зэргийг зураглан гаргах явдал юм.

Өдрийн тэмдэглэл- Тодорхой хэсэг хугацаанаас эхлэн хэдэн жил, бүр бүх насаараа тэмдэглэл хөтөлсөн бичмэл түүхийг өдрийн тэмдэглэл гэнэ. Энэ нь зохиолчийн өв, уран бүтээлийн нэг хэсэг, мөн хувийн нууц архив юм.

Өчиг- Сэтгэлийн өчиг нь үглэл ярианы нэг хэлбэр юм. Гадагшаа илэрдэггүй, баатрын сэтгэлийн дотоодод болдог яриа юм.

Байгалийн зураглал- Зохиолд байгалийн байдлыг урнаар дүрслэн бичихийг байгалийн зураглал гэнэ. Байгалийн зураглал нь үйл явдал болж байгаа газар орон, цаг улирлыг харуулах, баатрын сэтгэл санааг нээн харуулахад тус нэмэр болдог.

Захидал- Баатрын зан төрх, сэтгэл санааны хоорондын харилцааг илэрхийлэх, үйл явдлыг холбох зорилгоор хэрэглэдэг зохиомжийн бүрдэл хэсэг

Зүүд- Зохиолын баатар юм уу өгүүлэгчийн зүүдээр өнгөрсөн, ирээдүйд болох зүйлүүдийг болж байгаа мэтээр бичих аргыг хэлнэ

Уянгын халил- Зохиолын агуулгыг бүрдүүлэн нээх, үйл явдлын эрчимжилт, шийдлийн эгзэгтэй үе шатанд зохиолч зохиолынхоо шугамаас ямар нэгэн хэмжээгээр хазайж, өөр өгүүлэмж рүү халтиран орох, хувийн үнэлэлт, эргэцүүлэмж рүү шилжсэнээс үүсэн бий болдог үйл явдлын бүрдэл хэсэг юм

Оруулбар- Зохиолын явдлын системд шууд хамааралтай биш боловч уг хэрэг явдлын утга санааг нэмэн дэлгэрүүлэхэд тодотгол хийсэн шинжтэй тусгай хэсэг юм

Дасгал 1. Уран зохиолын зохиомжийн анхдагч төрх нь төлөвлөгөө юм. /Д.

Батбаяр “Бүтээхүйн зүй тогтол”, УБ, 2007 он, хуудас 123/ **Зохиолч бүтээлээ сонирхолтой болгохын тулд яаж зохиомжилсныг тодруулж уншъя.**

Алхам 1. /*Зураглал-4*/-ийг сайтар ажиглан, бодомжийг нөхөөрэй.

Байгалийн үзэгдэл болоод өрдсөн галынхаа хувьсал, өөрчлөлтийг дүрсэлсэн -тай дүрийнхээ сэтгэл санааны байдал, дурсамж ярианы уур амьсгалыг зохицолдуулж, гэсэн үйл явдлын шугамыг хоёрын -аар харуулсан нь агуулгын зохиомж болно.



Зураглал-4

Алхам 2. Түлсэн гал, ярьсан дурсамж, дүрийн сэтгэл зүй ямар холбоотой байгааг тодруулахын тулд түүвэрлэсэн хэсгийг анхааралтай уншаарай.

Тэгээд нарийхан цэнхэр утаа дээш дэгдэхэд өвгөн сая л гараа татаж босоод уугьж эхэлсэн галыг хормойгоороо хэд сэвтэл дөл цайлалзан, удалгүй гал дүрэлзэн аслаа.

Жанибек дотроос нь нэгнийг эрэх мэт дөл рүү ширтэн сууснаа надаас “Хэдтэй вэ?” гэж

асуулаа. Би “Хорин тавтай” гэлээ. Зовхио өргөн над руу нэг том харснаа аман дотроо нэг юм бувтнаснаас нь би ганцхан “...томоогүй золиг...” гэсэн үг ойлгож хоцорлоо.

Гал асч дуусав. Би баахан хуурай аргалын хог хамж цог руу хаяснаа, ахин явж бүтэн хормой аргал авчирч нэмлээ. Дүрэлзсэн гал асаасай гэж бодсон минь, дүрэлзсэн гал аслаа. Жанибек дөл рүү ширтсээр “Өвөлжөөний эзнийхээс хүн үлдээгүй юм” гэлээ.

Жанибекийн харц гал дээр тогтжээ. Тэрхүү байдал нь хоёр эриний босгон дээр ертөнцийн энэхэн алс бөглүү хязгаарыг донсолгосон шуурган жилүүдийн дүр зураг дөлөн дотроос түүний нүднээ амилан харагдаж байна уу даа гэсэн бодол төрүүлнэ.

Жанибекийн хоолой нь зангирс хийгээд дуугүй болчихлоо. Эргэн тойрон нам гүм. Бороо

зогсжээ. Гал асч дуусаад улайхын төдий цог л үлдсэн байв. Цогийг хөндөж, тойруулан аргал зэргэлэж, тархиа дүйртэл үлээлээ. Гал ахин дүрэлзэн асаасай гэж бодсон минь, гал ахин дүрэлзэн аслаа.

Өтөл нөхөр минь сүүлчийн үгийг нээрээ л хаширч хэлсэн тул хоолой нь зангирснаа дараа нь таг болчхов. Гал руу ширтэн гөлөрсөн нүдэнд нь бяцхан цэгээн нулимс гялсхийв.

Гал асч дуусаад гагцхүү нурамны захад дутуу шатан үлдсэн ганц хоёр аргалаас үзэгдэхийн төдий утаа савсана. Зовлонтой нам гүм байлаа. Гэтэл босч очоод аргал авчирч галыг сэргээчих зориг надад байсангүй. Унтарсан нурмыг өтөл нөхөр минь хув хуурай нүдээр гөлрөн сууна.

Хоцрон үлдэх нутаг эл хуль, доод газар нь дээд тэнгэртэйгээ өнчрөн эзгүйрсэн мэт атал гагцхүү асаагаад мордсон галаас минь дэгдэх цэнхэр утаа амьдралын бүлээн амьсгал тасраагүйг, тасардаггүйг илтгэх мэт ээ.

1. Галын хувьсал нь дурсамж ярианы ямар үеийг илтгэж байгааг зөв холбоорой?

Гал асч дуусаад...

Эхэлж буйг

Дөл цайлалзан, удалгүй гал дүрэлзэн аслаа.

Цааш үргэлжлэхийг

Гал ахин дүрэлзэн асаасай гэж бодсон минь, гал ахин дүрэлзэн аслаа.

Дуусч байгааг

2. Жанибекийн галын дөл рүү ширтээд байгаагийн шалтгаан буюу дараах томъёоллын хариуг олж бичээрэй.

(дөл рүү ширтэн сууснаа + дөл рүү ширтсээр + харц гал дээр тогтжээ + Гал руу ширтэн гөлөрсөн нүдэнд нь бяцхан цэгээн нулимс гялсхийв + Унтарсан нурмыг өтөл нөхөр минь хув хуурай нүдээр гөлрөн сууна) =

3. Зураглалыг ажиглан тохирох үгсийг нөхөж бичээрэй.

..... нурам = нүд = дурсамж → Гэсэн ч цэнхэр утаа амьдралын бүлээн амьсгал, илтгэх мэт ээ

“ Хүн даадаггүй даадаг ”

Уран зохиол бол хязгааргүй сэтгэх боломж...

Дууссан:онсар ...өдөр

